

**ИТАЛИ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМАНД
ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХ ВИЗ
МЭДҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ БАРИМТ БИЧИГ**

№	Баримт бичгийн төрөл	Анхаарах зүйлс
1	Визийн мэдүүлэг	<ul style="list-style-type: none"> – бүрэн бөглөсөн – нэг хувь цээж зургаа наасан – гарын үсгээ зурсан (насанд хүрээгүй хүүхдийн өмнөөс эцэг эх хоёулаа гарын үсэг зурсан байх) – огноогоо тавьсан
2	Паспорт	<ul style="list-style-type: none"> – сүүлийн 10 жил дотор олгогдсон байх – хүчинтэй үлдсэн хугацаа 6 сараас дээш байх – хоёр хоосон хуудастай байх – паспорт эх хувиараа байх – паспортын хуулбарыг хавсаргах – паспортын визтэй тамгатай хуудаснуудын хуулбар хавсаргах – хэрэв хуучин паспорт байгаа бол эх хувиар нь хавсаргах – хэрэв хуучин паспорт байгаа бол хуучин паспортын визтэй тамгатай хуудаснуудын хуулбар хавсаргах
3	Цээж зураг	<ul style="list-style-type: none"> – 3,5 см X 4,5 см хэмжээтэй байх – 2 ширхэг байх – цагаан дэвсгэртэй байх – ИСАО-н стандартын дагуу авсан байх
4	Их сургуулийн урилга	<ul style="list-style-type: none"> – Виз мэдүүлэгчийн хувийн мэдээллийг заасан байх – Хэрэв төлбөртэй хувийн их сургууль бол төлбөр төлсөн баримт болон урилгын эх хувь
5	Урьдчилсан бүртгэлийн баримт бичиг	<ul style="list-style-type: none"> – Бүрэн дунд болон дээд боловсролын гэрчилгээ, дипломны Dichiarazione di Valore эсвэл CIMEA-гийн гэрчилгээ – 12 жилийн бүрэн дунд боловсрол эзэмшээгүй бол дутуу жилээ нөхөн их сургуульд суралцсан тухай их сургуулийн тодорхойлолт, шалгалтын дүнгийн жагсаалт (<i>нотариатаар батлуулж Апостиль хийлгэсэн байх, шалгалтуудыг давсан байх</i>)
6	Хэлний мэдлэгийг нотолсон гэрчилгээ	<ul style="list-style-type: none"> – B2 эсвэл түүнээс дээш түвшний гэрчилгээ (CELI, TOEFL)
7	Санхүүгийн бололцоог харуулсан баримт бичиг	<ul style="list-style-type: none"> – Санхүүгийн зардлыг батлан дааж байгаа тухай эцэг эхийн хамтын мэдэгдэл (<i>нотариатаар баталсан байх</i>) – Эцэг эхийн ажлын газрын болон цалингийн тодорхойлолт – Эцэг эхийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн лавлагаа (<i>www.e-mongolia.mn сайтаас авсан байх</i>) – Өөрийн болон эцэг эхийн хадгаламж болон харилцах дансны сүүлийн 6 сарын хуулга (<i>банкаар баталгаажуулсан байх</i>) – Өөрийн төрсний лавлагаа (<i>www.e-mongolia.mn сайтаас авсан байх</i>)
8	Нислэгийн захиалгын хуудас	<ul style="list-style-type: none"> – Зорьж буй хот хүртэлх нислэгийг захиалга
9	Зочид буудлын захиалгын хуудас	<ul style="list-style-type: none"> – Зочид буудлын нэр, хаяг тодорхой байх

10	Аяллын эрүүл мэндийн даатгалын хуудас	<ul style="list-style-type: none"> – 30,000 евротой тэнцэх нөхөн олговрын хэмжээтэй байх – эх хувиараа байх – хуулбарыг хавсаргасан байх – 3 сарын хугацаатай байх
11	Визийн төлбөр	<ul style="list-style-type: none"> – төлбөр нь заасан дүнд тааруулсан байх – мөнгөн дэвсгэрт нь аливаа тэмдэглэгээгүй, урагдаж, гэмтээгүй байх <p>(Төлбөр нь 01.07.2021-30.09.2021 хугацаанд 171,850 төгрөг байна.)</p>
<ul style="list-style-type: none"> • Бичиг баримтыг дээрх дарааллын дагуу байрлуулна уу. • Хэрэв баримт бичиг итали болон англи хэл дээр биш бол эдгээр хоёр хэлний аль нэг дээрх орчуулгыг хавсаргана уу. • Дээр дурдсан баримт бичиг дээр нэмэлтээр өөр бусад төрлийн баримт бичгийг шаардаж болохыг анхаарна уу. 		